

**АРХИВЫН УЛСЫН ҮЗЛЭГИЙН МӨРӨӨР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2020.12.04

Хараат

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
Албан хэрэг хөтлөлтийн талаар			
1	2	3	4
1	Баримт бичигт зайлшгүй байх бүрдлүүд /Баримт бичиг хүлээн авсан тухай тэмдэглэл, баримт бичиг боловсруулсан тухай тэмдэглэл, Санамжид байгаа мэдээллийг эрж хайх тэмдэглэл/-ийг хийж хэвших, дутуу буюу буруу хийсэн, аливаа комисс, зөвлөлийн хурлын тэмдэглэлийг тамга, тэмдгээр баталгаажуулах.	Баримт бичигт зайлшгүй байх бүрдлүүдийг хийж хэвшсэн байна. Зөвлөлийн хурлын тэмдэглэлийг тамга, тэмдгээр баталгаажуулан ажилласан.	100%
2	Төрийн албан хаагчид албан хэргээ “Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын 6.3.5-д заасны дагуу бүрдүүлэх.	Албан байгууллага, албан хаагч нар албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу архивт баримтыг шилжүүлж байна.	100%
3	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг зааврын дагуу боловсруулах, жагсаалтад баримт бичгүүдийг нэр төрлөөр нь бүрэн хамруулах.	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулахдаа ажилтнуудын хөтлөгдөж буй баримт бичгийг зааврын дагуу боловсруулж жил бүр шинэчлэн байгууллагын даргаар батлуулан мөрдөж байна.	100%
Байгууллагын архивын ажлын талаар			
1	Архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, архивын өрөө, хадгаламжийн санг зааврын дагуу тохижуулах.	Архивын өрөөг шинэчлэн засварлаж, зориулалтын 4ш төмөр тавиурыг 1800000 төгрөгөөр худалдан авч, өрөөний цахилгааны шугам сүлжээг далд байршуулан, гэрлийг төмөр бүрхүүлтэй болгож, чийг дулаан хэмжигч, галын хор, архивын өрөөний хаалгыг төмөр болгон, шалыг плита болгож стандартын дагуу тохижуулсан.	100%
2	Байгууллагын ББНШК-ын хурлыг тогтмолжуулж, бүртгэл жагсаалтаа хэлэлцэн, Төрийн архивын дэргэдэх ББНШАЗК-ын хурлаар бүрэн хэлэлцүүлж, батлуулан ажиллах.	ББНШК-ын үйл ажиллагаа тогтмолжиж 2-оос доошгүй удаа хуралддаг. ББНШК-ын хурлаар баримтын хадгалах хугацааг хэлэлцүүлэн нягтлан шалгадаг. 2004-2012 оны байнга, түр хадгалах,	100%

		устгах хэргийн актыг 2013.09.06-ны 3 дугаар хуралдаан, байнга хадгалах 2009-2016, түр хадгалах 2006-2016, устгах хэргийн актыг 2004-2005 он хүртэлхийг 2017.06.08-ны 2 дугаар хуралдаан, 2012-2018 оны байнга хадгалах, 2017-2018 оны түр хадгалах, 2006-2008 оны устгах хэргийн актыг 2019.06.13-ны өдрийн 4 дүгээр хуралдаанаар тус тус хэлэлцүүлж ББШАЗК-оор батлуулсан.	
Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, цахим сан бүрдүүлж буй байдлын талаар			
1	“Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгайлан тусгаж ажиллах.	Байгууллагын төсөвт шаардагдах тоног төхөөрөмжийн зардлыг тусгаж, архивын өрөөнд зориулалтын стандартын төмөр шүүгээ 1800000 төгрөгөөр 4ш авч байрлуулсан. 2019 онд архивын өрөөг аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар засварласан.	100%
2	Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх.	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх заалтуудыг тусгаж хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр хэрэгжүүлж ажиллаж байна.	70%
3	Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу хэрэгжилтийг тайлагнах.	Засгийн газрын 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу бодлогын бичиг баримтын хэрэгжилтийг тухай бүр хугацаанд нь тайлагнаж ажилласан.	100%
4	Албан хэрэг хөтлөлт, архивын программгүй байгууллагууд программтай болох асуудлыг шийдвэрлэх.	2019 онд байгууллагын төсвөөс 330,000 төгрөгөөр “ARMS” /Archive records/ программыг авсан. Албан хэрэг хөтлөлтийн программ дээр удирдлагын баримт бичиг 2010-2020 он хүртэл шивж, скайнердаж оруулсан.	100%
5	Байгууллагын архивт хөтлөгдөж буй тоо бүртгэлийн үндсэн болон туслах баримт бичигт цахимжуулсан баримтын талаар	Албан хэрэг хөтлөлтийн программд 2009-2020 оны нийт 120 гаруй баримтыг шивж, скайнердаж, CD	100%

	тэмдэглэл хийх ажлыг зохион байгуулах.	дээр буулгаж цахимжуулаад байна. /Албан байгууллага тус бүрээр нь/	
Хэрэгжилт 97%			